



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ "БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧДЫН СИСТЕМ"-ИЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2019 он



This project is funded
by the European Union.

Төслийн Санхүүжүүлэгч Европын холбоо

Албан бус орчуулга

Эмхэтгэсэн: Ц.Хулан /МҮХАҮТ-Хэрэглэгч, үйлчилгээний газар/

Хэвлэх хэмжээ: А5 /148х210мм/

Хэвлэлийн хуудас: 6х.х



“Эрдэнэзул” ХХК-д
хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Монгол улсын худалдааг дэмжих ТРАМ төсөлтөй хамтран Европын Холбооны “Бүртгэгдсэн Экспортлогчдын Систем” (REX) гарын авлагыг экспортлогч, худалдаа эрхлэгч та бүхэнд танилцуулж байна.

Европын Холбоо (ЕХ)-ны “GSP”+ Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хүрээнд импортын барааны татварын хөнгөлөлт эдэлж буй бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлийг цахимжуулж, түүнийг Монгол улс 2020 оны 01 дүгээр сарын 01—ний өдрөөс эхлэн (ЕХ)-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-ийг нэвтрүүлж буйтай холбогдуулан Монгол Улсын Гадаад Харилцааны яам (ГХЯ), Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар (ГЕГ), Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) хамтран хэрэгжүүлэхээр болоод байна. Уг “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-д аж ахуйн нэгжүүдийг бүртгүүлэх, бүртгэлийн санг хөтлөх үйл ажиллагааг МҮХАҮТ гүйцэтгэх гэж байна.

Энэхүү гарын авлагыг та өөрийн бизнесийн үйл ажиллагаанд ашигласнаар REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-д хэрхэн бараа бүтээгдэхүүнийхээ гарал үүслийг бие даан мэдүүлэх талаар бүрэн ойлголттой болохоос гадна ЕХ-ны зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортлоход дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Таньд амжилт хүсье.

МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн

"Бүртгэгдсэн экспортлогчдын систем"-ийн гарын авлага

**Европын Холбооны Бүртгэгдсэн Экспортлогчдын Систем
(БЭС)**

Ерөнхий тодорхойлолт

Энэхүү гарын авлага нь дүрслэн тайбарлах үүрэгтэй. Гаалийн хууль тогтоомжууд нь энэхүү баримт бичгийн агуулгыг тодорхойлон чиглүүлнэ. Европын Холбооны хууль эрх зүйн бичиг баримтуудын эх бичвэр нь Европын Холбооноос гаргасан албан ёсны хэвлэмэл материалд нийтэлсэн байна. Энэ нь мөн үндэсний хэмжээний зөвлөмжүүд байж болно.

Гарчиг

ТОВЧЛОЛ	6
1. ОРШИЛ	7
2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
3. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧ БОЛОХ НӨХЦЛҮҮД	8
4. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧ БОЛОХ ЖУРАМ	10
1. Өргөдөл гаргагчийн мэдээлэл	10
2. Эрх бүхий байгууллагуудын экспортлогчдын бүртгэл	13
3. Бүртгэлийн маягтыг хүлээн авснаас хойш бүртгэлд оруулах хугацаа	14
4. Бүртгэлийн хүчинтэй хугацаа	14
5. ЭКСПОРТЛОГЧДЫН БҮРТГЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ	15
• Экспортлогчдын бүртгэлийн өөрчлөлт	15
• Экспортлогчдын бүртгэлийг хүчингүй болгох	15
6. ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ГАРГАХ (СОЛИХ)	16
1. Гарал үүслийн баталгаажуулалтыг хэн гаргаж болох вэ?	17
2. Гарал үүслийн баталгаажуулалтын загвар	18
3. Гарал үүслийн баталгаажуулалттай хавсаргах худалдааны бичиг баримтууд	19
4. Худалдааны бичиг баримтанд гарал үүслийг тодорхойлох нь	20
7. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧИД БОЛОН БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЭЛД ТАВИХ ХЯНАЛТ	20
8. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧДЫН ХҮЧИНТЭЙ БАЙДЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	22
9. ЕВРОПЫН ХОЛБООНЫ ГУРАВДАГЧ ОРНУУДАЙ БАЙГУУЛСАН ЧХХ-Т БЭС-ИЙН ТАЛААР ОРУУЛСАН ЗААЛТ ..	23
10. ХАВСРАЛТ 1 - ӨРГӨДЛИЙН МАЯГТ	25

ТОВЧЛОЛ

Товчлол	Тодорхойлолт
EORI буюу ЭЗҮАБ дугаар	Эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэлийн дугаар
FTA буюу ЧХХ	Чөлөөт худалдааны хэлэлцээр
GSP буюу ХЕС	Хөнгөлөлтийн ерөнхий систем
OCT буюу ГУОНД	Гадаадын улс орнууд буюу нутаг дэвсгэрүүд
REX system	Экспортлогчдын бүртгэлийн систем
TIN буюу УБД	Улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар
WCO буюу ДГБ	Дэлхийн гаалийн байгууллага

1. Оршил

Энэхүү баримт бичиг нь бүртгэгдсэн экспортлогчдын бүтээгдэхүүний гарал үүслийн баталгаажуулалтыг бие даан мэдүүлэх экспортлогчдын бүртгэлийн системтэй холбоотой удирдамж болно. БЭС нь 2017 оны 1-р сарын 1-нээс ХЕС-ийн хүрээнд мөрдөгдөж байгаа бөгөөд гарал үүслийн дүрмийг 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ) болон Холбооны Гаалийн Код (Но. 952/2013 тоот журам (ЕХ)-д тогтоосон байна. Цаашилбал, БЭС нь давуу эрх бүхий худалдааны хэлэлцээрт гарал үүслийг тодорхойлход мөн ашиглагдана. Тухайлбал, Канад болон Вьетнам улсуудтай байгуулсан ЧХХ-т БЭС-ийг ЕХ-нд ашиглаж болох талаар урьдчилан тусгасан байна. 2020 оны 1-дүгээр сарын 1-нээс 755/2013/EU тоот Зөвлөлийн шийдвэрийн Хавсралт 6-д гарал үүслийн дүрмийн талаар дурьдсаны дагуу БЭС-ийг Гадаад улс орнууд буюу нутаг дэвсгэрт нэвтрүүлнэ.

ЕХ-ны гуравдагч орнуудтай байгуулсан нэг талт, хоёр талт, олон талт худалдааны хөнгөлөлттэй хэлэлцээрүүдэд БЭС-ийг ашиглах тул энэхүү гарын авлагыг бие даасан баримт бичиг болгон цаашид БЭС–тэй холбоотой гарын авлагуудад (ХЕС-ийг Хэрэглэгчдийн гарын авлага, ЧХХ-ийн удирдамж...) лавлагаа болгох үүднээс гаргасан.

Уг баримт бичиг нь гаалийн байгууллагуудад экспортлогчдыг бүртгэх болон бүртгэлийг цаашид үргэлжлүүлэх үйл ажиллагааг хөнгөвчлөх зөвлөмжүүдийг багтаасан. Мөн түүнчлэн экспортлогчдод барааныхаа гарал үүслийг баталгаажуулах үйл ажиллагааг хөнгөвчлөх зөвлөмжүүдийг мөн агуулна.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. БЭС нь бүртгэгдсэн экспортлогчдод бараа бүтээгдэхүүнийхээ нэхэмжлэл буюу худалдааны бусад баримт бичгүүд дээр тусгай мэдүүлэг (өөрөөр хэлбэл гарал үүслийн баталгаажуулалт) хавсаргаснаар гарал үүслийг өөрөө баталгаажуулах боломжийг олгон экспортын үйл ажиллагааг хөнгөвчилнө. Иймээс, бүртгэгдсэн экспортлогч нь экспортын үйл ажиллагааг явуулах бүрт гарал үүслийн гэрчилгээг авах шаардлагагүй болно.

2. Бүртгэгдсэн экспортлогч болохын тулд экспортлогч нь эрх бүхий байгууллагад шаардлагатай бүртгэлийн мэдээллийг өгнө.

3. БЭС –ийн дугаарыг авмагч бүртгэгдсэн экспортлогч нь өөрийн экспортын бүх үйл ажиллагаанд тухайн дугаарыг ашиглан гарал үүслийн гэрчилгээний систем үйлчилж буй хөнгөлөлттэй

зохицуулалтыг эдэлнэ.

4. Бүртгэгдсэн экспортлогчийн баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээг “гарал үүслийн баталгаажуулалт” гэнэ. Зарим тохиолдолд “гарал үүслийн мэдүүлэг” гэж нэрлэдэг (тухайлбал Канад улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээр буюу СЕТА).

5. Европын Холбоо нь гуравдагч орнуудтай байгуулсан хөнгөлөлттэй нөхцлийн хэлэлцээрийн жагсаалтыг дараахь линкээр орж танилцана уу:

http://ec.europa.eu/taxation_customs/customs/customs_duties/rules_origin/preferential/article_779_en.htm.

Хөнгөлөлттэй нөхцлийн хэлэлцээр бүр өөрийн дүрэм журмын дагуу “Бүртгэгдсэн экспортлогчийн системийг” бий болгодог ба өөрөөр хэлбэл БЭС-ийн дугаарыг эзэмшигч нь олон талт бүртгэлийг бий болгож байгаа бөгөөд тухайн ашиглалт бүр нь тодорхой заалттай гэдгийг анхаарах нь зүйтэй.

6. БЭС-ийн журмыг 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ) дахь ХЕС-ийн агуулгад тусгасан. Уг журмын 68(1) –р зүйлд тусгаснаар, ХЕС-ийн заалтуудыг холбогдох өөрчлөлтүүдийг харгалзан Холбооны ХЕС-ийн схемээс гадуур хүрээнд БЭС –ийг хэрэглэхэд ашиглана. Уг баримт бичиг нь цаашид шаардагдах давуу эрх бүхий худалдааны хэлэлцээрүүдэд ХЕС-ийн заалтуудын холбогдох өөрчлөлтүүдийг харгалзан нарийвчлан судална.

7. ХЕС-д хамрагдагч орнууд БЭС-ийг 2017 оны 1-р сарын 1-нээс 2020 оны 6-р сарыг дуустал аажмаар нэвтрүүлэх юм. ХЕС-ийн гарал үүслийн журмууд нь шилжилтийн үеийг нарийвчлан тодорхойлно. ХЕС-д хамрагдагч орнуудын БЭС-ийг нэвтрүүлсэн хугацааг дараахь холбоосоор харж болно:

https://ec.europa.eu/taxation_customs/registered-exporter-system_en

3. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧ БОЛОХ НӨХЦЛҮҮД

1. (ЕХ-нд) ЕХ-ны нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлогч, үйлдвэрлэгч болон борлуулагч, эсвэл дамжуулан борлуулагч нь эрх бүхий байгууллагад хандан бүртгэгдсэн экспортлогч болох эрхтэй бөгөөд экспортлох болон дамжуулан борлуулах гэж буй бүтээгдэхүүнийхээ өөрийн баталгаажуулсан гарал үүслийг нотлоход шаардлагатай баримтуудыг гаалийн байгууллагаас шаардсан үед гаргаж өгөх үүрэгтэй. Гишүүн орнуудад төвтэй бөгөөд өөр гишүүн орнуудад байр

буюу агуулахтай ЕХ-ны аж ахуйн нэгж нь эдгээр гишүүн орнуудын аль нэгэнд нь (хэрэв өөр өөр компаниуд өөр өөр ЭЗҮАБ дугаартай бол аль алинд нь) бүртгүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Аль нэгэн гишүүн оронд өөрийн ЭЗҮАБ дугаараар бүртгүүлсэн аж ахуйн нэгж нь өөр гишүүн оронд тухайн бүртгүүлсэн дугаараар дахин бүртгүүлж болохгүй.

2. (ХЕС-ийн дагуу хөнгөлөлт эдлэгч улс орнууд) ХЕС-д хамрагдах улсуудын нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлогч, үйлдвэрлэгч болон борлуулагч нь эрх бүхий байгууллагад хандан бүртгэгдсэн экспортлогч болох эрхтэй бөгөөд экспортлох гэж буй бүтээгдэхүүнийхээ өөрийн баталгаажуулсан гарал үүслийг нотлоход шаардлагатай баримтуудыг гаалийн байгууллагаас шаардсан үед гаргаж өгөх үүрэгтэй.

Аливаа нэгэн экспортлогч нь өөрийн байнга орших буюу салбар төвөө байгуулсан улсын эрх бүхий байгууллагад хандан бүртгүүлэх эрхтэй.

3. Экспортлогч нь тогтсон үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэгч буюу худалдаа эрхлэгч байна.
4. Бүртгэгдсэн экспортлогч нь эрх бүхий байгууллагууд шаардсан үед холбогдох бараа бүтээгдэхүүний гарал үүслийг нотлоход шаардлагатай баримтуудыг гаргаж өгөх боломжтой байх ёстой.
5. Бүртгэгдсэн экспортлогч нь эрх бүхий байгууллагууд шаардсан үед бараа бүтээгдэхүүний санхүүгийн болон үйлдвэрлэлийн явцын баталгаажуулалтыг хүлээн зөвшөөрөх ёстой.
6. Бүртгэгдсэн экспортлогч нь өөрийн гаргасан гарал үүслийн баталгаажуулалтын хувийг бусад холбогдох баримт бичгүүдийн хамт доод тал нь 3 жилийн хугацаанд (давуу эрхийн гэрээнд болон ЕХ гишүүн улсуудын үндэсний хууль тогтоомжинд заасан хугацаанаас хамааран илүү хугацаатай байж болно) хадгалах ёстой. Энэхүү хугацаа нь давуу эрхийн гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан хуанлийн жилийн эцсээс эхэлнэ.
7. Бүртгэгдсэн экспортлогч нь өөрийн бүртгэлийн дугаарын ашиглалттай холбоотой бүх хариуцлагыг хүлээнэ.
8. Бүртгэгдсэн экспортлогч нь бүртгэлийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтүүдийг эрх бүхий байгууллагуудад мэдэгдэх үүрэгтэй.

4. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧ БОЛОХ ЖУРАМ

Шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагууд өргөдөл гаргагчдад хөнгөлөлтийн журмын талаар сургалт явуулж болно.

Эрх бүхий байгууллагууд нь экспортлогчдод бүртгэгдсэн экспортлогч болоход шаардлагатай нөхцлүүдийг тайлбарлах үүднээс зааварчилгаа өгч болно. Ийм зааварчилгааг интернэтээр болон цаасан хэлбэрээр өгч болно. Зааварчилгаанаас гадна ухуулах хуудас зэрэг мэдээллийн бусад хэлбэрүүд байж болно.

1. Өргөдөл гаргагчийн гаргаж өгөх шаардлагатай мэдээллүүд
 1. ХЕС-ийн хүрээнд бүртгэгдсэн экспортлогч болох хүсэлтэй аж ахуйн нэгж нь 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын Хавсралт 22-06-д (уг журмын 1-р хавсралт) дурдсан мэдээллүүдийг гаргаж өгөх үүрэгтэй.
 2. Ерөнхий Мэдээллийн 2.6-д зааснаар - Хавсралт 22-06-д тусганыг Холбооны ХЕС-ийн схемээс гадуур хүрээнд экспортлогчдыг бүртгэхэд холбогдох өөрчлөлтүүдийг харгалзан дагаж мөрдөнө. Энэхүү баримт бичгийн Хавсралт 2-ыг Холбооны ХЕС-ийн схемээс гадуур хүрээнд өргөдлийн маягтаар ашиглахыг зөвлөнө.
3. Өргөдөл гаргагчийн гаргаж өгөх шаардлагатай мэдээллүүд:
 - 1-р хүснэгт: Аж ахуйн нэгжийн нэр, бүтэн хаяг, улсын нэр, ЭЗҮАБ дугаар эсвэл ХЭБД
 - ЭЗҮАБ дугаар эсвэл ХЭБД:
 - EORI буюу ЭЗҮАБ дугаар нь холбооны хүрээнд эдийн засгийн үйл ажиллагаа явуулахад олгодог Эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэлийн дугаар юм.
 - TIN буюу ХЭБД нь Худалдаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар юм. Энэ нь Дэлхийн Гаалийн Байгууллагаас тухайн улсын эдийн засгийн операторуудыг өвөрмөцөөр тодорхойлох зорилготой өгөгдлийн элемент юм. Цаашид ХЕС-д хамрагдах улсууд болон ГУОНД нь, хараахан хийгээгүй бол, өөрийн аж ахуйн нэгжүүдээ бүртгэхийн өмнө TIN буюу улсын бүртгэлийн дугаар олгох ёстой.
 - Экспортлогчийн нэр. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 70].
 - Гудамж болон дугаар. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 70].
 - Шуудангийн код. Өгөгдлийн формат нь [хавсралт

- 9]. Хэрэв тухайн оронд хотууд нь шуудангийн код байдаггүй тохиолдолд тухайн мэдээллийг оруулах шаардлагагүй.
- Хотын нэр. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 35].
 - Улсын нэр. Заавал байх ёстой мэдээлэл.
 - Цахим шуудангийн хаяг, факсын дугаар, утасны дугаар. Эдгээр 3 зүйлийн дор хаяж аль нэг нь заавал байх ёстой. Өгөгдлийн формат нь [хавсралт 50].
- 2-р хүснэгт. Утас болон факсын дугаар, электрон шуудангийн хаяг зэрэг холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл
 - 1-р хүснэгтний агуулга нь холбоо барих гол мэдээлэл зэрэг компаний талаар ерөнхий мэдээллийг агуулдаг бол 2-р хүснэгт нь БЭС системийн агуулгад тохирсон нарийвчилсан мэдээллийг агуулдаг (тухайлбал, ах ахуйн нэгжийн гарал үүслийн асуудлыг хариуцсан ажилтан). 2-р хүснэгтийг заавал бөглөх шаардлагагүй бөгөөд хэрэв бүртгэгдсэн экспортлогч нь 1-р хүснэгтэнд оруулсан мэдээллээс өөр холбоо барих мэдээллийг оруулах шаардлагатай гэж үзвэл бөглөж болно.
 - Нэр. Заавал оруулах шаардлагагүй. Өгөгдлийн формат нь [хавсралт 70].
 - Гудамж болон дугаар. Заавал оруулах шаардлагагүй. Өгөгдлийн формат нь [хавсралт 70].
 - Шуудангийн код. Өгөгдлийн формат нь [хавсралт 9]. Заавал оруулах шаардлагагүй.
 - Хотын нэр. Заавал оруулах шаардлагагүй. Өгөгдлийн формат нь [хавсралт 35].
 - Улсын нэр. Заавал оруулах шаардлагагүй.
 - Цахим шуудангийн хаяг, факсын дугаар, утасны дугаар. Заавал оруулах шаардлагагүй. Өгөгдлийн формат нь [хавсралт 50].
 - 3-р хүснэгт. Үндсэн үйл ажиллагаа нь үйлдвэрлэл эсвэл худалдаа эрхлэх гэдгийг зааж өгөх
 - Аль нэг нь эсвэл хоёулаа байж болно
 - 4-р хүснэгт. Хөнгөлөлтөнд хамрагдах нөхцлийг хангасан барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС) оруулсан тодорхойлолт (эсвэл борлуулж буй

бараа нь барааны кодын гарчгуудын хориос дээш бүлэгт багтаж байгаа бол).

- Барааны жагсаалт нь тодорхойлогч заалт бөгөөд энэхүү жагсаалтанд ороогүй бүтээгдэхүүнд гарал үүслийн баталгаажуулалт хүссэн экспортлогчдод татгалзах шалтгаан болох ёсгүй. Хэдийгээр тийм боловч ийм тохиолдлууд нь импортлогч талын гаалийн байгууллагыг дараахь шатны баталгаажуулалтыг хийх шалтгаан болдог (эргэлзэх үндэсдэслэлтэй эсвэл ямар нэгэн зүйлээс хамааралгүй).

Ийм тохиолдолд экспортлогч талын эрх бүхий байгууллагууд бүртгэгдсэн экспортлогчид бүртгэлийн мэдээллээ шинэчилж шинэ Барааны код авахыг санал болгож болно.

- Өгөгдлийн формат нь [д... 4]. (бүлгийн дугаар эсвэл гарчигийн дугаар).
- 5-р хүснэгт: Экспортлогчийн үүрэг
 - Эрх бүхий хүний гарын үсэг. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 35].
 - Гарын үсэг зурсан огноо. Заавал байх ёстой мэдээлэл.
 - Гарын үсэг зурах эрх бүхий хүний нэр. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 70].
 - Гарын үсэг зурах эрх бүхий хүний албан тушаал. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 17].
- 6-р хүснэгт: Олон нийтийн вэбсайт дээр өөрийн мэдээллийг нийтлэх зөвшөөрөл экспортлогчоос авах (олон нийтэд мэдээлэх нийтлэлийн талаар 8-р хэсэгт тодорхой тайлбарласан).

Экспортлогч нь хэвлэн нийтлэх тодорхой зөвшөөрлийг өгөхдөө энэ хүснэгтийг бөглөнө. Үүнд:

- Эрх бүхий гарын үсгийг зурсан газар. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 35].
- Гарын үсэг зурсан огноо. Заавал байх ёстой мэдээлэл.
- Гарын үсэг зурах эрх бүхий хүний нэр. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь

[хавсралт 70].

- Гарын үсэг зурах эрх бүхий хүний албан тушаал. Заавал байх ёстой мэдээлэл. Өгөгдлийн формат нь [хавсралт 17].

Хүснэгт 5 болон 6-д үйл ажиллагаа болон мэдээллийг хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгосон экспортлогчийн гарын үсэг байна. Экспортлогч нь өргөдлийг цаасан хэлбэрээр эрх бүхий байгууллагуудад өгсөн тохиолдолд гараар бичсэн гарын үсэг байх шаардлагатай. Тухайн өргөдлийг мөн цахим хэлбэрээр эрх бүхий байгууллагад гаргаж болно. Ийм тохиолдолд тухайн экспортлогч нь бүртгэгдсэн экспортлогчийн системд бүртгэлтэй, цахимаар өргөдөл гаргах эрхээ авсан байх шаардлагатай.

2. ЭКСПОРТЛОГЧИЙН БҮРТГЭЛ (МҮХАҮТ)

1. Эрх бүхий байгууллага нь экспортлогчийн гаргасан өргөдөл бүрэн гүйцэд, оруулсан мэдээллүүд нь үнэн бодит тохиолдолд бүртгэлийг хийнэ.
2. Эрх бүхий байгууллага нь бүртгэлийг хийх үедээ экспортлогчийн гаргасан өргөдлийн 7-р хүснэгтийг бөглөнө. Хүснэгт 7 нь (зөвхөн эрх бүхий байгууллагын албан хэрэгцээнд) дараахь мэдээллийг агуулна:
 - а. Бүртгэлийн дугаар (БЭС дугаар): эрх бүхий байгууллагаас олгосон дугаар байна. Энэхүү дугаар нь улсын ISO код (хоёр үсэгт), БЭС (гурван үсэгт) болон 30 хүртэл үсэг тоон тэмдэгт зэргээс бүрдэнэ.
 - б. Бүртгэлийн огноо: эрх бүхий байгууллагаас бүртгэлийг баталгаажуулсан огноог заана.
 - в. Бүртгэлийн бүрэн эрх эхлэх хугацаа: эрх бүхий байгууллага нь бүртгэлийн бүрэн материалыг хүлээн авсан огноог заана.
 - г. Экспортлогчийг бүртгэсэн эрх бүхий байгууллагын гарын үсэг, тамга (доорх 4-р зүйлд заасны дагуу шаардлагатай үед ашиглана).
3. Зохион байгуулалтын үүднээс, экспортлогчийг бүртгэж байгаа байгууллага нь өргөдөл гаргагчийн өргөдөлдөө оруулсан мэдээллийг шалгах чадвартай байх нь зүйтэй.
4. Эрх бүхий байгууллага нь бүртгэлийн ажиллагааг дуусмагц экспортлогчдод мэдэгдэнэ. Мэдэгдлийг цаасан хэлбэрээр гаргасан тохиолдолд уг баримт бичгийг энэхүү баримт бичгийн

Хавсралт 1 болон Хавсралт 2-т дурьдсаны дагуу гаргана. Ийм тохиолдолд, өргөдлийн 7-р хүснэгтэнд заасан “гарын үсэг болон тамга” гэсэн мэдээллийг экспортлогчийн бүртгэж буй эрх бүхий байгууллага гараар бөглөнө. БЭС-ийн Мэдээллийн технологийн систем нь тухайн зорилгоор ашиглаж болох өргөдлийн маягтыг (7-р хүснэгтийн мэдээллийг багтаасан) хэвлэж гаргахад тусална. Эрх бүхий байгууллагаас бүртгэгдсэн экспортлогчид гаргасан мэдэгдлийг цахим хэлбэрээр гаргасан тохиолдолд баталгаажуулалтыг цахимаар хийж байгаа тул тамга болон гараар бичсэн гарын үсэг шаардлагагүй.

5. Эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчид илгээсэн цаасан буюу цахим мэдэгдлийн хувийг хадгална.

3. ЭКСПОРТЛОГЧИЙН ӨРГӨДЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ БҮРТГЭХ ХУГАЦААНЫ ХЯЗГААР

1. Экспортлогчийг бүртгэхэд албан ёсны цаг хугацааны хязгаар байхгүй боловч 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын холбогдох заалтанд (дугаар зүйл 80 (2)) бүртгэлийг “хойшлуулалгүйгээр” хийнэ гэж заасан байна (уг баримтын 1-р Хавсралт).

4. ЭКСПОРТЛОГЧИЙН БҮРТГЭЛИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

1. Бүртгэлийн хугацаа цаг хугацааны хувьд хязгааргүй.
2. Бүртгэлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн арга хэмжээг авсан эрх бүхий байгууллага нь хүчингүй болгох хугацааг мэдэгдэнэ. Тухайн тохиолдолд бүртгэл нь хүчингүй болох хугацааг хүртэл хязгаарлагдмал хугацаатай байна.
3. Холбоонд бүртгэгдсэн экспортлогч нь гарал үүслийн баталгаажуулалт хэрэглэдэг худалдааны хэлэлцээрт БЭС-ийн хүрээнд өөрийн бүртгэлийн дугаарыг ашиглаж болно. Бүртгэлийн мэдээлэл нь ерөнхий бөгөөд худалдааны давуу эрх олгох гэрээтэй ямар нэгэн тодорхой холбоо байхгүй (тухайлбал, өргөдлийн маягтанд гэрээнүүдийн гарал үүслийн аль нэг журамтай тодорхой холбоо байхгүй).
4. ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудын бүртгэгдсэн экспортлогч нь ЕХ, Швейцарын, Норвегийн болон цаашид Туркийн (шаардлагатай тохиолдолд) ХЕС-ийн тарифын хөнгөлөлттэй нөхцлөөр бараа бүтээгдэхүүн экспортолоходоо бүртгэлийн

дугаараа ашиглаж болно. Эдгээр гурван улсын (Турк улс БЭС-д элссэнээр 4 болно) гарал үүслийн журам ижил төстэй тул БЭС-ийн ижил Мэдээллийн технологийн системийг ашиглах шийдвэр гарсан бөгөөд ХЕС-ийн хөнгөлөлт эдлэгч орнуудын экспортлогчдоос зөвхөн нэгдсэн бүртгэлийг шаарддаг.

5. ЭКСПОРТЛОГЧИЙН БҮРТГЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

1. ЭКСПОРТЛОГЧИЙН БҮРТГЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

1. Бүртгэгдсэн экспортлогч нь бүртгэлийн мэдээлэлд орсон бүх өөрчлөлтүүдийн талаар эрх бүхий байгууллагуудад мэдэгдэх үүрэгтэй.
2. Бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахын тулд бүртгэгдсэн экспортлогч нь өөрчлөлт хариуцсан эрх бүхий байгууллагад өргөдөл (бичгээр эсвэл цахим хэлбэрээр, баталгаажуулсан тохиолдолд цахимаар) гаргах үүрэгтэй. Мэдээлэлд өөрчлөлт оруулах талаар хууль тогтоомжинд оруулсан загвар байхгүй. Экспортлогчид нь өргөдлийн маягтыг (энэхүү баримтын 1 болон 2-р хавсралт) ашиглан эрх бүхий байгууллагуудад өөрчлөлт хийх хүсэлтийг гаргаж болно.
3. Эрх бүхий байгууллагууд нь өргөдөл гаргагчид бүртгэлийн өөрчлөлт амжилттай болсон эсэх талаар бичгээр эсвэл цахим хэлбэрээр баталгаажуулсан тохиолдолд цахимаар мэдэгдэнэ. Уг тохиолдолд экспортлогчийг анхлан бүртгэх 4.2.4.-д дурьдсан журмыг дагаж мөрдөхийг санал болгоно.
4. БЭС-ийн хүрээнд гарал үүслийн баталгаажуулалтыг хэрэглэхэд хийгдэх бүртгэл нь бүх эрхзүйн хүрээнд автоматаар хүчинтэй байдаг тул худалдааны хэлцлүүд хийгдэхэд бүртгэлийг шинэчлэх шаардлагагүй (4.4.3-ыг харна уу).

2. ЭКСПОРТЛОГЧИЙН БҮРТГЭЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

1. Бүртгэгдсэн экспортлогч нь дараахь тохиолдолд БЭС –ээс гаргах хүсэлтийг өөрийн биеэр гаргана:
 - а. БЭС –ээс тавьж буй шаардлагыг хангахгүй тохиолдолд
 - б. Бүртгэлийн дугаарыг цаашид ашиглахгүй тохиолдолд
 - в. Аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа зогсоож буй тохиолдолд
2. Бүртгэгдсэн экспортлогчийг хянах явцдаа эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчийг санаатайгаар эсвэл хайхрамжгүй

- байдлаасаа болж алдаатай мэдээлэл агуулсан гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан үйлдлийг илрүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчийг цуцална.
3. Бүртгэгдсэн экспортлогчийг хянах явцдаа эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчийг байхгүй болсон гэдгийг илрүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчийг цуцална.
 4. Бүртгэгдсэн экспортлогчийг хянах явцдаа эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчийг БЭС –ийн шаардлагыг цаашид хангахгүй байгааг (тухайлбал, мэдээллээ цаг тухайд нь шинэчлээгүй бөгөөд тухайн хийгдэх ёстой өөрчлөлтийг ноцтой гэж үзвэл) илрүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллага нь бүртгэгдсэн экспортлогчийг цуцална.
 5. Экспортлогчийн цуцлагдсан дугаарыг шинээр экспортлогч бүртгэхэд ашиглаж болохгүй.
 6. Өмнө нь бүртгүүлээд бүртгэлээ цуцлуулсан экспортлогч нь дахин бүртгүүлэх өргөдөл гаргасан тохиолдолд эрх бүхий байгууллага нь тухайн экспортлогчид бүртгэлийн шинэ дугаар өгөх бөгөөд өмнө нь цуцлагдсан дугаарыг дахин ашиглахгүй (цуцлалтыг хүчингүй болгох тохиолдлыг эс тооцвол).
Эрх бүхий байгууллага нь бүртгэлийг цуцлахад хүргэсэн алдаагаа арилгасан эсэхийг гэрчлэн, үнэн зөв мэдээллийг өгсөн гэдгийг баталгаажуулсан тохиолдолд тухайн экспортлогчийг бүртгэнэ.
 7. Цуцлалтыг хүчингүй болгосон тохиолдолд (экспортлогч нь хүчингүй болгосныг эсэргүүцэн давж заалдах шатанд заргаа авсан эсвэл алдааны улмаас цуцалсан тохиолдолд) тухайн экспортлогчид өмнөх (цуцалсан) дугаарыг дахин олгож болно.
 8. Бүртгэгдсэн экспортлогчийн хууль эрхзүйн байдалд өөрчлөлт орсны улмаас шинээр үүссэн аж ахуйн нэгж нь шинэ EORI буюу ЭЗУАБ дугаар (Холбооны хүрээнд) эсвэл шинэ TIN буюу улсын бүртгэлийн дугаар (ХЕС –ийн хөнгөлөлт эдлэгч орнууд) авсан тохиолдолд одоо байгаа бүртгэлийг цуцлан шинээр үүссэн компанид шинэ дугаар өгөх нь зүйтэй.

6. ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ГАРГАХ (СОЛИХ)

Гарал үүслийн баталгаажуулалтын журамд Холбооны хүрээнд гаргасан гарал үүслийн баталгаажуулалтыг солих асуудлыг мөн

тусгасан.

Хэрэглэгчийн зааврыг экспортлогчийг амжилттай бүртгэсэн гэсэн мэдэгдэлтэй хавсаргаж болно. Уг зааварчилгаанд экспортлогчид хэрэгтэй дараахь мэдээлэл багтана.

1. ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ХЭН ГАРГАЖ БОЛОХ ВЭ

1. Ерөнхий зарчимын хувьд, гарал үүслийн баталгаажуулалтыг гаргаж буй экспортлогч нь барааны гарал үүслийг батлан, үүнийгээ баталгаажуулах чадвартай байх ёстой.
Гарал үүслийн баталгаажуулалтыг гаргаж буй бүртгэгдсэн экспортлогч нь үйлдвэрлэгч биш (тухайлбал, худалдаа эрхлэгч) тохиолдолд түүнд тухайн барааны гарал үүслийг нотлоход шаардлагатай бүхий л баримт бичгүүд (нийлүүлэгчийн мэдүүлэх хуудас ...) байх ёстой бөгөөд үүнийгээ баталгаажуулах чадвартай байх ёстой.
2. ХЕС-ийн хүрээнд, хөнгөлөлт эдлэгч улсаас Европын Холбооруу гаргах барааны гарал үүслийн баталгаажуулалтыг солиход (бүртгэгдсэн) экспортлогч нь 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 92 (1) заалтын дагуу хийнэ.
3. ХЕС-ийн хүрээнд, илгээгдэж буй барааны үнэ босго үнэнээс доогуур тохиолдолд бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй аливаа экспортлогч нь гарал үүслийн баталгаажуулалтыг гаргана. Ийм тохиолдолд хөнгөлөлт эдлэгч орон гарал үүслийн гэрчилгээний А формыг хууль ёсоор олгох боломжгүй (2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 79(3) заалт).
4. 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 101-р зүйлд тусгасны дагуу, ЕХ-нд барааг дамжуулан борлуулагч (бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй) нь хөнгөлөлттэй нөхцлийн хэлэлцээртэй оронд гаргасан гарал үүслийн баталгаажуулалтыг солих мэдэгдлийг гаргаж болно.
Зөвхөн БЭС –д бүртгэлтэй дамжуулан борлуулагч нь Норвеги болон Швейцарь улсуудад гаргах гэж буй барааны гарал үүслийн баталгаажуулалтыг солих мэдэгдлийг гаргаж болно.
5. 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 69(4)-р зүйлд тусгасны дагуу, ЕХ-нд барааг дамжуулан борлуулагч (бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй) нь чөлөөт худалдааны хэлэлцээрийн хүрээнд гаргасан гарал үүслийн баталгаажуулалтыг солих мэдэгдлийг гаргаж болно.
6. 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 69(2)-р

зүйлд тусгасны дагуу, ЕХ-нд барааг дамжуулан борлуулагч (бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй) нь чөлөөт худалдааны хэлэлцээрийн хүрээнд гаргасан гарал үүслийн гэрчилгээ, гарал үүслийн мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн мэдүүлгийг солих мэдэгдлийг гаргаж болно.

2. ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗАГВАР

1. ХЕС-ийн хүрээнд гарал үүслийн баталгаажуулалтын агуулгыг 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 22-07 хавсралтад тусгасан (энэ баримт бичгийн Хавсралт 3-т байна).
2. Ерөнхий Мэдээллийн 2.6-д зааснаар, Хавсралт 22-07-д тусганыг Европын Холбооны ХЕС-ийн схемээс гадуур хүрээнд экспортлогчдыг бүртгэхэд холбогдох өөрчлөлтүүдийг харгалзан дагаж мөрдөх бөгөөд үүнд холбогдох давуу худалдааны хөнгөлөлттэй
3. хэлэлцээрт гарал үүслийн баталгаажуулалтын текстийг тусгаагүй гэж заасан. Энэ нь энэхүү баримт бичгийн Хавсралт 4-т байна.
4. ЧХХ-ийн хүрээнд БЭС-ийг ашиглаж байгаа үед гарал үүслийн баримт бичгийн текст өгөгдсөн тохиолдолд ЕХ-ны экспортлогчид нь уг текстийг хэрэглэх үүрэгтэй. Тухайлбал, Канад улстай хийсэн гэрээнд гарал үүслийн баталгаажуулалтын текстийг тусгасан байдаг. Уг тохиолдолд, ЕХ-нд бүртгэлтэй экспортлогчид уг гэрээний хүрээнд гарал үүслийн баталгаажуулалтыг гаргахдаа тухайн гэрээнд өгөгдсөн текстийн дагуу бэлдэнэ.
5. Илгээгдэж буй барааны үнэ босго үнэнээс дээгуур тохиолдолд гарал үүслийн баталгаажуулалтанд бүртгэлийн дугаарыг заавал оруулна (ХЕС болон ЧХХ-ийн хүрээнд 6 000 Евро, ГУОНД – д 10 000 Евро).

Илгээгдэж буй барааны үнэ босго үнэнээс доогуур тохиолдолд аливаа экспортлогч нь, бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй үл хамааран, гарал үүслийн баталгаажуулалтыг гаргаж болно.

Үнийн дүнг экспортлогч орны холбогдох байгууллага нь евро-д хөрвүүлэн тооцох бөгөөд экспортын үйл ажиллагааг дуусх хүртэл хугацаанд өөрчлөлт оруулах ёсгүй. Үнэлгээ хийхэд ИНКОТЕРМС (EXW, CIF, FOB, DDU ...) тодорхойлолт хамаарахгүй. Иймд, үнэлгээг гаргахдаа ИНКОТЕРМ нөхцлийг харгалзан тооцох эсэхээ тухайн экспортлогч орон шийднэ.

Худалдааны баримт бичигт гарал үүслийн баталгаажуулалтанд дурьдсан гарал үүслийн шалгуур адил бус байвал үүнийг

тодорхой зааж өгнө. Тухайлбал, бараа болгоны хажууд гарал үүслийн шалгуурыг зааж, гарал үүслийн баталгаажуулалт дээр “худалдааны баримт бичигт бараа болгоны хажууд заасан” гэдгийг дурьдана.

6. Гарал үүслийн баталгаажуулалтанд экспортлогчийн гараар бичсэн гарын үсэг шаардлагагүй.
ЧХХ-ийн хүрээнд, бүртгэгдсэн экспортлогч гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан тохиолдолд ЧХХ-т гарал үүслийн баримт бичиг үзэглээгүй байж болно гэж тусгасны дагуу тухайн баримт бичигт гарын үсэг тавиагүй байж болно.
7. Гарал үүслийн баталгаажуулалтанд экспортлогчийн нэр тодорхой байх ёстой. Энэ нь гуравдагч этгээдэд мөн илт байх ёстой.
8. Нэхэмжлэл эсвэл бусад худалдааны баримт бичиг дээр экспортлогчийн шивж, хэвлэн тамгалаж гаргасан гарал үүслийн баталгаажуулалт нь гарал үүслийг тодорхой тодорхойлно.
9. Худалдааны баримт бичигт бэхэлсэн шошгон дээрх гарал үүслийн баталгаажуулалт нь зөвхөн тухайн худалдааны баримт бичгийг гаргасан газраас эсвэл бүртгэгдсэн экспортлогч өөрөө бэхэлсэн тохиолдолд зөвшөөрөгдөнө.

3. ГАРАЛ ҮҮСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТТАЙ ХАВСАРГАХ ХУДАЛДААНЫ БИЧИГ БАРИМТУУД

1. Нэхэмжлэх дээр гаргасан гарал үүслийн баталгаажуулалт; өөрөөр хэлбэл, бүртгэгдсэн экспортлогч нь тодорхой бөгөөд үүнтэй холбоотойгоор бараа хүлээн авагч түүний гарал үүслийг ямар нэгэн эргэлзээгүйгээр тайлбарлах боломжтой нөхцөлд гарал үүслийн баталгаажуулалтыг худалдааны өөр баримт бичиг дээр гаргаж болно. Энэ нь тэмдэглэл, худалдааны нэхэмжлэх эсвэл сав баглаа боодлын жагсаалт зэргийг дагалдуулж болно.
2. Тооцооны хуудас, агаарын замын хуудас зэрэг тээврийн баримтыг тээвэрлэгч, тээвэр зууч гаргадаг тул худалдааны баримт бичигт тооцохгүй.
3. Гарал үүслийн баталгаажуулалтыг тусдаа хуудсан дээр өгч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн хуудас нь уг баримтын нэг хэсэг гэдэг нь тодорхой байх ёстой.
4. Хэрэв худалдааны баримт нь хэд хэдэн хуудсаас бүрдсэн тохиолдолд хуудас бүрийг дугаарлан нийт хуудсын тоог заасан байх ёстой.

4. ХУДАЛДААНЫ БИЧИГ БАРИМТАНД ГАРАЛ ҮҮСЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

1. Гарал үүслийг тодорхойлсон баримт бичигт барааг таних боломжийг хангах үүднээс нарийвчлан тайлбарласан байна.
2. Гарал үүсэлгүй бүтээгдэхүүнийг тодорхой тодорхойлно. Гарал үүсэлтэй болон гарал үүсэлгүй барааг ялгахын тулд мөр бүрийн ард хаалтанд гарал үүсэлтэй барааг зааж болно. Цаашилбал, нэхэмжлэх дээр гарал үүсэлтэй болон гарал үүсэлгүй гэсэн хоёр гарчиг оруулж, тус бүрийн доор холбогдох барааг жагсаан оруулж болно. Өөр нэг шийдэл бол бүх барааг дугаарлан, эцэст нь аль дугаарууд гарал үүсэлтэй, аль нь гарал үүсэлгүй гэдгийг зааж болно.
3. Нэхэмжлэх эсвэл худалдааны баримт дээр жагсаасан бараа нь давуу эрх эдэлдэг өөр өөр улс болон газар нутгаас (ХЕС-ийн хүрээнд бүс нутгийн хуримтлал байж болно) гарал үүсэлтэй бол улс болон газар нутгийн нэр эсвэл албан ёсны товчлолыг (ISO код) заах ёстой. Өмнөх хэсэгт дурьдсан боломжуудын мөн ашиглаж болно. Гарал үүслийн баталгаажуулалтын текст сонгосон шийдлээс хамааран тодорхой байх ёстой.

7. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧИД БОЛОН БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЭЛД ТАВИХ ХЯНАЛТ

1. ХЕС-ийн хүрээнд, хөнгөлөлт эдлэгч орнуудын эрх бүхий байгууллагууд эсвэл ЕХ-ны гишүүн орнуудын гаалийн байгууллагууд гарал үүслийн баталгаажуулалтанд дурьдсан гарал үүслийн байдлыг холбогдох заалтуудад тусгасан гарал үүслийн журмын дагуу шалгах, баталгаажуулах ажлыг хийнэ:
 - а. импортлогч талын хүсэлтээр нэг буюу хэд хэдэн гарал үүслийн баталгаажуулалтыг хийх.
 - б. эрсдлийн шинжилгээний шалгуурууд дээр үндэслэн өөрсдийн санаачилгаар хийх. Шалгалтанд орох экспортлогч болон гарал үүслийн баталгаажуулалт нь барааны төрөл, үйлдвэрлэлийн салбар болон очих орон зэргээс хамаарахгүй боловч эрсдлийн шинжилгээнд эдгээр элементүүдийг харгалзан үзэж болно. Ийм шалгалтын давтамж нь эрсдлийн шинжилгээний үр дүн эсвэл өмнөх шалгалтын үр дүнгээс хамаарч болно. Энэ зорилгоор, ашиг хүртэгч орны эрх бүхий байгууллагууд экспортлогчдоос тэдгээрийн гаргасан гарал үүслийн баталгаажуулалтын хувийг эсвэл жагсаалтыг өгөхийг

шаардах ёстой.

2. ЧХХ-ийн хүрээнд гарал үүслийн баримт бичгүүдийг бүртгэгдсэн экспортлогчид гаргадаг тул ЕХ-ны гишүүн орнуудын гаалийн байгууллагууд өөрийн санаачилгаар экспортлогчдын шалгалтыг эрсдлийн шинжилгээний зохих шалгуур дээр үндэслэн тогтмол явуулах шаардлагатай. Энэ нь 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 108-р зүйлд тусгасан ЧХХ-ийн агуулгыг 68(1) зүйлтэй уялдуулан хэрэгжүүлэхтэй холбоотой.
3. Хяналтын байгууллага нь экспортлогчийн гаргасан хүсэлт дээр үндэслэн экспортлогчийн байранд шалгалтыг явуулж болно; сүүлчийн аргыг экспортлогч нь үйлдвэрлэгч гэсэн тохиолдолд ашиглахыг илүүд үздэг.

Дараахь үйл ажиллагааг явуулж болно:

- a. бүртгэгдсэн экспортлогчийн экспортолсон бараа түүхий эдийн гарал үүслийн нотолгоог баталгаажуулах хүсэлт ирсэн тохиолдолд бараа түүхий эдийн гарал үүслийн баталгаажуулалтыг шалгах.
 - b. Бүртгэгдсэн экспортлогчид бусад аж ахуйн нэгжээс худалдан авсан бараа түүхий эдийн гарал үүслийн нотолгоо болох нийлүүлэгчийн мэдүүлгүүдийн нарийвчлалыг баталгаажуулах үүднээс INF-4 (ЕХ-нд) мэдээллийн гэрчилгээг шаардах зэрэг Нийлүүлэгчийн мэдүүлгүүдийг шалгах.
 - v. Экспортлогчийн гаргасан бүтээгдэхүүн эсвэл ашигласан түүхий эдийн худалдааны урсгалыг экспортлогчийн өгсөн санхүүгийн мэдээлэлтэй харьцуулах.
4. Эрх бүхий байгууллагууд нь өөрийн орны бүртгэгдсэн экспортлогчдын бүртгэлийн хүчинтэй хугацаанд нь мэдээллийг нь үнэн зөв гэдгийг (экспортлогч нь одоо байгаа эсэх; хаяг нь өөрчлөгдөөгүй; холбогдох хүний мэдээлэл хүчинтэй хэвээр эсэх...) тогтмол хянах шаардлагатай.
 5. Эрх бүхий байгууллагууд нь өөрийн орны бүртгэгдсэн экспортлогчдод бүртгэлийн нөхцлийг дагаж мөрдсөөр байгаа эсэх болон үүнээс үүдэх хариуцлагыг хангах үүднээс тогтмол аудитын шалгалт хийх шаардлагатай.
 6. Уг шалгалтыг явуулах захиргааны байгууллага болон үйлчилгээний тодорхойлолт нь Гишүүн Улс бүрийн (эсвэл ХЕС-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэгч орон) хариуцлага юм. Гишүүн улсын хүрээнд (эсвэл ХЕС-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэгч орон) ажил үүргийн хуваарилалтын дагуу уг хяналтыг өөр өөр

байгууллагад хариуцуулж болно.

7. Зөрчил илэрсэн тохиолдолд өөр өөр төрлийн залруулах арга хэмжээнүүдийг авч болно, тухайлбал:
 - а. Бүртгэгдсэн экспортлогч нь бүртгэлийн мэдээлэл дээр бага зэргийн өөрчлөлт гарсныг мэдэгдээгүй зэрэг бага хэмжээний зөрчил дээр анхааруулга өгөх. Үүнд мөн бүртгэгдсэн экспортлогч нь өөрийн бүртгэлийн жагсаалтанд мэдүүлээгүй барааны гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан тохиолдолд орж болно (мэдүүлгийн маягтны 4-р хүснэгт).
 - б. Бүртгэлийн зохих ажиллагаанд нөлөөлөхгүй зөрүү илэрсэн тохиолдолд цаашдын нөхцлийг хангах үүднээс бүртгэгдсэн экспортлогчийг шинэчлэлт хийхийг шаардаж болно.
 - в. Бүртгэгдсэн экспортлогчийг хүчингүй болгох (бүртгэлийг хүчингүй болгох талаар 5-р догол мөрийг харна уу).

8. БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДЛЫГ ШАЛГАХ

1. БЭС-ийн мэдээллийг эдийн засгийн операторуудтай зөвлөлдөх үүднээс DG TAXUD олон нийтийн вэбсайт дээр байрлуулсан: http://ec.europa.eu/taxation_customs/dds2/eos/rex_home.jsp?Lang=en
2. Өргөдлийн маягтны 6-р хүснэгтэнд гарын үсэг зурж өөрийн мэдээллийг нийтэд зарлахыг зөвшөөрсөн тохиолдолд бүх мэдээллийг DG TAXUD –ын олон нийтийн вэбсайт дээр байрлуулна.
3. Өргөдлийн маягтны 6-р хүснэгтэнд гарын үсэг зуралгүй өөрийн мэдээллийг нийтэд зарлах зөвшөөрөл олгоогүй тохиолдолд DG TAXUD –ын олон нийтийн вэбсайт дээр мэдээллийн нэргүй дэд хэсгийг байрлуулна. Мэдээллийн дэд хэсэгт: бүртгэгдсэн экспортлогчийн тоо (бүртгэлийн дугаар), бүртгэл хүчинтэй байх огноо, боломжтой тохиолдолд бүртгэлийн хүчингүй болох хугацаа, бүртгэл нь Норвеги, Швейцарь эсвэл Турк улсуудруу экспорт хийхэд хамаарах эсэх талаар мэдээлэл, БЭС-ийг олон нийтийн вэбсайтаар хамгийн сүүлд уялдуулсан огноо. Уг мэдээлэл нь бүртгэлийн хугацааг хүчинтэй эсэхийг шалгахад хангалттай.
4. ЕХ-ны импортлогчид нь гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан бүртгэгдсэн экспортлогчдын хүчинтэй эсэхийг БЭС-

ийн мэдээлэл байршуулсан DG TAXUD –ын олон нийтийн вэбсайтаас үргэлж шалгах ёстой.

5. ХЕС-ийн хүрээнд бүс нутгийн эсвэл хоёр талын хэлэлцээрт оролцож буй хөнгөлөлт эдлэгч орнууд нь өөрийн бүтээгдэхүүнд ашигласан түүхий эдийн гарал үүслийг нотлох гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан бүртгэгдсэн экспортлогчдын хүчинтэй эсэхийг үргэлж шалгах ёстой.
6. Гарал үүслийн баталгаажуулалт нь тухайн бүртгэгдсэн экспортлогчийн хүчинтэй хугацаанд гаргасан тохиолдолд хүчинтэй байна. Хүчингүй болсон бүртгэгдсэн экспортлогч нь хүчингүй болхоосоо өмнө гарал үүслийн баталгаажуулалтыг гаргасан тохиолдолд тухайн баримт хүлээн зөвшөөрөгдөнө.

9. ЕХ ГУРАВДАГЧ ОРНУУДАЙ БАЙГУУЛСАН ЧХХ-ИЙН ХҮРЭЭНД БЭС-ИЙГ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖИЙГ ОЛГОХ ЗААЛТ

1. 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын 68 (1)-р зүйлд тусгахдаа
 1. “Холбоо нь **экспортлогч гарал үүслийн баримт бичгийг Холбооны хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэхийг** шаардсан давуу эрхийн зохицуулалттай бол зөвхөн гишүүн орнуудын гаалийн байгууллагуудад тухайн зорилгоор бүртгэлтэй экспортлогч уг баримт бичгийг бүрдүүлнэ. Тухайн экспортлогчдын хэн болохыг БЭС-д 2015/2447 тоот Үүрэг Хэрэгжүүлэх Журам (ЕХ)-ын хавсралтад зааснаар тэмдэглэнэ. Энэ хэсгийн 2-оос 9-дүгээр дэд хэсгүүдийг холбогдох өөрчлөлтүүдийг харгалзан хэрэглэнэ.
 2. ЕХ болон Канад улсын хооронд байгуулсан ЧХХ-т:
Энэ баримт бичгийн Хавсралт 5 нь ЕХ болон Канад улсын хооронд байгуулсан ЧХХ-ийн 19-р Зүйлд тусгасан Гарал Үүслийн Протоколын текстийг харуулна. 19(1)(а)-р Зүйлд тусгаснаар: “Экспортлогч нь Гарал үүслийн баталгаажуулалтыг 18.1-д зааснаар ЕХ-ны холбогдох хууль тогтоомжтой уялдуулан Европын Холбоонд бүрдүүлнэ”.
 3. ЕХ болон Вьетнам улсын хооронд байгуулсан ЧХХ-т:
Энэ баримт бичгийн Хавсралт 6 нь ЕХ болон Вьетнам улсын хооронд байгуулсан ЧХХ-ийн 25-р Зүйлд тусгасан Гарал Үүслийн Протоколын текстийг хуулбарласан. 25(1)-р Зүйлд

тусгаснаар: “Холбооноос гаралтай бүтээгдэхүүнийг Вьетнамд импортоор оруулахад тус **Холбооны холбогдох хууль тогтоомжтой уялдуулан цахим мэдээллийн санд бүртгэлтэй экспортлогч гарал үүслийн баталгаажуулалтыг ирүүлсний дараа** Холбооноос ийм хууль тогтоомж тэдний экспортлогчдод үйлчилнэ гэдгийг Вьетнам улсад мэдэгдсэний дараа энэхүү Хэлэлцээрийн дагуу давуу эрхийг эдэлнэ”.

**ЕВРОПЫН ХОЛБОО, НОРВЕГИ, ШВЕЙЦАРЬ, ТУРК УЛСУУДЫН
ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМД ХАМРАГДАХ
БҮРТГЭГДСЭН ЭКСПОРТЛОГЧ БОЛОХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

<p>1. Экспортлогчийн нэр, хаяг, улс, аж ахуй нэгжийн эрхлэгчийн бүртгэлийн дугаар, улсын бүртгэлийн дугаар, эсвэл регистрийн дугаар</p>
<p>2. Холбоо барих: Утас, факс, имэйл хаяг</p>
<p>3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлно уу:</p> <p>Бүтээгдэхүүн:</p> <p>Худалдаа эрхлэгч:</p>
<p>4. “Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем”-д хамаарах бараа, бүтээгдэхүүний жагсаалт, гаалийн татварын хөнгөлөлттэй журамд заасан барааны тодорхойлолт (эсвэл “Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем”-ийн 20 гаруй чиглэлээс худалдаалах бараа бүтээгдэхүүний бүлгийг тодорхойлох)</p> <p>5901 номын хавуу хавтас хийхэд хэрэглэгддэг цавуу, цардуулаар нааж бүрсэн сүлжмэл даавуу, хувцас хээгээр чимэглэх, зураг зурахад зориулан бэлтгэсэн зотон даавуу, метрийн зотон даавуу, малгайн хатуулга хийхэд зориулсан хаатууруулсан сүлжмэл даавуу</p> <p>5903 боловсруулсан, давхарласан, бүрхсэн уян чанартай нэхмэл даавуун зотон</p>

5. Экспортлогч талаас хийх үйл ажиллагаа:

Үүгээр дор гарын үсэг зурж баталгаажуулна:

- Дээрх зүйлсийг үнэн зөв гэдгийг батлах;
- Өмнөх бүртгэлийн хүчинтэй байх хугацааг батлах; хэрэв аливаа өөрчлөлт хийгдсэн бол түүнийг баталгаажуулах;
- Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу барааны гарал үүслийг тодорхойлох дүрэм журамд нийцүүлэн тарифын хөнгөлөлттэй бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн мэдүүлгийг гаргах;
- Бүртгэлийн баримт: (Бүртгэгдсэн экспортлогчдын Системд хөнгөлөлттэй нөхцөлийн дагуу бараа бүтээгдэхүүнийхээ мэдээллээ оруулснаас хойш хуанлийн жил дууссанаас хойш дор хаяж 3 жилийн хугацаанд);
- Бүртгэгдсэн экспортлогчийн дугаар авснаас хойш бүртгэлийн эзэмшигчийн мэдээлэлд өөрчлөлт орох бол тухайн мэдэгдлийг яаралтай эрх бүхий байгууллагад мэдэгдэх;
- Европын Холбоо эсвэл түүний гишүүн орнуудын эрх бүхий байгууллага, тэр дундаа Норвеги, Швейцарь, Турк хүсэлтийн дагуу Хөнгөлөлт эдлэгч орны эрх бүхий байгууллагаар экспортлогч Нягтлан бодох бүртгэлийн тайлан, гарал үүслийн мэдүүлгийн баталгааны хуудсанд хяналт шалгалт хийхийг зөвшөөрөх;
- Бүртгэлийн системээс гарах хүсэлт илгээвэл цаашид бараа, бүтээгдэхүүнийг экспортлох хөнгөлөлттэй нөхцөл эдлэхгүй;
- Бүртгэлийн системээс гарах хүсэлт илгээвэл цаашид бараа бүтээгдэхүүнийг экспортлохгүй.

..... /гарын үсэг/

Улаанбаатар хот

Огноо

Албан тушаалтны нэр:

Албан тушаал:

6. Экспортлогчийн хувийн мэдээллийг олон нийтийн вэб сайтад байршуулах тухай зөвшөөрөл авах

Дор гарын үсэг зурснаар экспортлогчийн маягт дээрх хувийн мэдээллээ олон нийтийн вэб сайтаар дамжуулан нийгэмд ил болгох, нийтлэхийг зөвшөөрч байна. Мөн бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллагууд руу хүсэлт явуулснаар энэхүү мэдээлэл нийтлэх зөвшөөрлийг цуцлах эрхтэй.

..... /гарын үсэг/

Улаанбаатар хот

Огноо

Албан тушаалтны нэр:

Албан тушаал:

Интернетэд хувийн мэдээлэл байршуулах зөвшөөрөл

Хөнгөлөлтийн Ерөнхий Систем дэх Бүртгэгдсэн экспортлогчийн хувийн мэдээллийг боловсруулах, хамгаалах тухай

1. Европын Холбооны Комисс нь “бүртгэгдсэн экспортлогч болох өргөдөл”-ийн маягтын хувийн мэдээллийг боловсруулахдаа ЕХ-ны Зөвлөл болон ЕХ-ны Парламентаас гаргасан экспортлогчийн хувийн мэдээллийг хамгаалах, мэдээллийн чөлөөт хөдөлгөөний тухай 45/2001 дүгээр тогтоолыг дагаж мөрддөг.
2. (Норвеги, Швейцар, Турк) эрх бүхий байгууллага, бусад гуравдагч орны хувьд “бүртгэгдсэн экспортлогч болох өргөдөл”-ийн маягтын хувийн мэдээллийг боловсруулахдаа 95/46/ЕС дугаар захирамж болон энэ захирамжтай холбогдох үндэсний хууль тогтоомжийн заалтыг дагана.
3. “Бүртгэгдсэн экспортлогч болох өргөдөл”-тэй холбоотой хувийн мэдээллийг ЕХ-ны хууль тогтоомжийн дагуу Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн гарал үүслийн тухай журамд нийцүүлэн боловсруулдаг. Бүртгэгдсэн экспортлогч болох өргөдлийн маягыг боловсруулах эрх зүйн үндэслэлийг ЕХ-ны Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн гарал үүслийн журмаар зохицуулдаг.

4. Өргөдлийн маягтыг хүлээн авч буй орны эрх бүхий байгууллага нь Хөнгөлөлтийн Ерөнхий Систем дэх хувийн мэдээллийг боловсруулахад хяналт, шалгалтын үүрэг гүйцэтгэнэ. *Холбогдох эрх бүхий байгууллага, гаалийн байгууллагын жагсаалтыг ЕХ-ны Комиссын вэб сайтаас үзнэ үү./*
5. ЕХ-ны гишүүн орнууд болон Норвеги, Швейцарь, Турк зэрэг орны гаалийн байгууллагууд, хүлээн авагч орны эрх бүхий байгууллагуудаар дамжуулан өргөдлийн маягтад нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгийг авах боломжтой.
6. ЕХ-ны гишүүн орны гаалийн байгууллага болон Хөнгөлөлт эдлэгч орны холбогдох эрх бүхий байгууллага нь хүчингүй болгосон экспортлогчийн бүртгэлийн мэдээллийг 10 жилийн хугацаатай хадгална. Хадгалалтын хугацаа нь хүчингүй болгох шийдвэр гарсан тухайн жилийн сүүл үеэс эхлэн тооцогдоно.
7. Европын Комиссын 45/2001 дүгээр тогтоол, үндэсний хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх тухай 95/46/ЕС дугаар захирамжийн дагуу Бүртгэгдсэн Экспортлогчийн систем дэх мэдээлэлд нэвтрэх эрхтэй ба шаардлагатай тохиолдолд өгөгдлийг арилгах, засах, хаах эрхтэй байна. Шаардлагатай бол хүлээн авагч орны холбогдох эрх бүхий байгууллага болон ЕХ-ны гишүүн орны гаалийн байгууллага нь мэдүүлгийн маягтад нэвтрэх, өгөгдлийг засах, хаах саналыг хүлээн авч, бүртгэл хийх эрхтэй байна. Бүртгэгдсэн экспортлогч нь ЕХ руу эдгээр эрхийг эдлэх тухай саналаа явуулна. Харин Комисс тухайн саналыг авч, хүлээн авагч талын эрх бүхий байгууллага болон ЕХ-ны гишүүн орны гаалийн байгууллага руу тус тус илгээнэ. Хэрэв бүртгэгдсэн экспортлогч өргөдлийн мэдээлэлд хяналт тавих эрх авч чадахгүй бол хянагчийн үүрэг гүйцэтгэх Комисс руу саналаа хүргүүлнэ. Энэ тохиолдолд Комисс нь бүртгэгдсэн экспортлогчийн өмнөөс өргөдлийн мэдээллийг засах, устгах эрхтэй байдаг.

8. Аливаа санал, гомдлыг Үндэсний Мэдээллийг Хамгаалах Байгууллагад гаргах боломжтой. Мөн Үндэсний Мэдээллийг Хамгаалах Байгууллагатай холбоо барих бол Европын Комисс, Ерөнхий Шүүхийн Захиргааны Зөвлөлийн /EDPS/ доорх вэб сайтаас харна уу. http://ec.europa.eu/justice/data-protection/bodies/authorities/eu/index_en.htm#h2-1

Харин Европын Холбооны Комиссоос боловсруулсан мэдээллийн талаар санал гомдол гаргах бол Европын Мэдээллийг Хамгаалах Хяналтын газарт хүргүүлнэ үү. <http://www.edps.europa.eu/EDPSWEB/>

- I. Европын Холбоо болон Норвеги, Швейцар, Турк улсын Хөнгөлөлтийн Ерөнхий Системд энэхүү өргөдлийн маягт нь нийтлэг ажиглагддаг. Гэсэн ч эдгээр Хөнгөлөлтийн Ерөнхий Систем нь тухайн орны нөхцөл байдал, бараа, бүтээгдэхүүний хамрах хүрээнээс шалтгаалан өөр байж болно. Иймд, тухайн бүртгэл нь хөнгөлөлт эдлэгч тал гэж үзэн Хөнгөлөлтийн Ерөнхий Систем дор экспорт хийж буй үед хүчин төгөлдөр байна.
- II. Европын Холбоо руу бараа экспортлох, ачаа дамжуулах үед аж ахуй нэгж эрхлэгчийн (EORI number) бүртгэлийн дугаарыг шаардана. Хөнгөлөлт үзүүлж буй орнууд ЕХ болон Норвеги, Швейцар, Турк зэрэг улсууд руу бараа, бүтээгдэхүүн экспортлох, ачаа дамжуулах бол улсын бүртгэлийн дугаарыг (TIN number) шаардана.